



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/15/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2022 он

Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор: Г.Мөнхчимэг
Утас: 260512 Цахим хаяг: munkhchimegg@aaudit.gov.mn
Нью Эстимэйтор Аудит ХХК
Аудитор: Б.Халиунаа Утас: 95157097, 99993667
Цахим хаяг: jukhertar@yahoo.com

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦЭНГЭГ УСНЫ НӨӨЦ БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Ч.БАТСАНСАР ТАНАА

2022.02.25 № 07/370
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	64,577,931.20	334,159,263.20
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	
33	Авлага	-	270,620,000.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	-	270,620,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	64,577,931.20	63,539,263.20
351	Түүхий эд материал	48,357,714.20	47,113,414.20
35110	Тусгай зориулалттай материал	48,357,714.20	47,113,414.20
354	Хангамжийн материал	16,220,217.00	16,425,849.00
35410	Бичиг хэргийн материал	761,349.00	1,054,010.00
35420	Аж ахуйн материал	216,700.00	217,970.00
35440	Түлш шатах тослох материал	69,000.00	264,000.00
35450	Барилгын засварын материал	1,701,300.00	1,850,800.00
35470	Бусад хангамжийн материал	13,471,868.00	13,039,069.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,511,797,850.01	5,170,666,027.43
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,511,797,850.01	5,170,666,027.43
392	Биет хөрөнгө	5,510,887,850.01	5,158,256,860.77
39201	Барилга, байгууламж	4,682,259,087.00	4,682,259,087.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(118,086,730.20)	(214,154,713.56)
39203	Авто тээврийн хэрэгсэл	89,155,183.28	89,155,183.28
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,045,470.45)	(41,872,227.77)
39205	Машин, тоног төхөөрөмж	776,514,700.00	786,263,673.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,355,200.16)	(237,257,676.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	227,145,950.00	234,311,170.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(162,788,552.44)	(188,523,484.96)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	36,306,300.00	36,806,300.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,539,100.00	22,539,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,756,517.02)	(11,269,551.06)
39217	Номын фонд	-	-
393	Биет бус хөрөнгө	910,000.00	12,409,166.66
39301	Программ хангамж	1,210,000.00	14,210,000.00
39302	Хасагдуулаг	(300,000.00)	(1,800,833.34)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,576,375,781.21	5,504,825,290.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	5,576,375,781.21	5,504,825,290.63
51	Засгийн газрын хувь оролцоо	5,576,375,781.21	5,504,825,290.63
512	Хуримтлагдсан үр дүн	5,558,388,824.92	5,486,838,334.34
51210	Өмнөх үеийн үр дүн	3,186,307,730.12	5,558,388,824.92
51220	Тайлант үеийн үр дүн	2,372,081,094.80	(71,550,490.58)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	17,986,956.29	17,986,956.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,576,375,781.21	5,504,825,290.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,283,356,573.78	741,556,394.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	846,262,873.78	19,874,194.46
120	Нийтлэг татварын бус орлого	846,262,873.78	19,874,194.46
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	846,262,873.78	19,874,194.46
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,837,600.00	2,960,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	842,425,273.78	16,914,194.46
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	437,093,700.00	721,682,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	399,578,700.00	381,332,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	399,578,700.00	381,332,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,515,000.00	340,349,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	17,200,000.00	335,415,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчаас	20,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	4,934,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	549,513,560.98	813,106,885.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	549,513,560.98	813,106,885.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	528,451,285.02	806,098,425.21
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	285,993,626.57	286,674,635.34
210101	Цалин	210,469,000.00	205,079,335.34
210102	Нэмэгдэл цалин	58,372,926.57	63,144,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,151,700.00	18,451,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,004,234.29	38,610,500.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,563,934.29	27,170,400.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,860,100.00	2,860,000.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,288,100.00	2,288,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	572,000.00	572,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,720,100.00	5,720,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,292,647.35	29,094,712.67
210301	Гэрэл цахилгааны зардал	19,142,462.00	14,784,885.95
210302	Түлш, халаалтын зардал	10,474,345.35	10,462,086.72
210303	Цэвэр, бохир усны зардал	2,675,840.00	3,847,740.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,707,804.83	10,510,930.16
210401	Бичиг хэргийн материал	1,567,060.00	1,507,569.00
210402	Тээвэр, шатахууны зардал	2,316,500.00	1,529,000.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	5,316,065.83	4,628,302.16
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,643,881.00	1,601,759.00
210408	Бараа материал акталсны зардал	12,864,298.00	1,244,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	303,800.00	3,063,900.00
210604	Урсгал засвар	303,800.00	3,063,900.00
2107	Томилолт, зочны зардал	1,858,000.00	3,778,000.00
210702	Дотоод томилолтын зардал	1,858,000.00	3,778,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	33,866,634.00	40,245,930.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,877,200.00	38,340,910.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	171,434.00	196,020.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	318,000.00	165,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,424,537.98	394,119,817.04
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	17,581,500.00	22,573,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,843,037.98	371,546,017.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,062,275.96	7,008,459.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,484,000.00	2,847,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,484,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	2,847,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,578,275.96	4,160,959.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,263,275.96	4,160,959.83
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	315,000.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	733,843,012.80	(71,550,490.58)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	1,647,116,072.00	
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,647,116,072.00	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	8,877,990.00	
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,877,990.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4=145-225)	1,638,238,082.00	
5	НИЙТ ҮР ДҮН (5=3+4)	2,372,081,094.80	(71,550,490.58)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	17,986,956.29	3,186,307,730.12	3,204,294,686.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	2,372,081,094.80	2,372,081,094.80
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	17,986,956.29	5,558,388,824.92	5,576,375,781.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	17,986,956.29	5,558,388,824.92	5,576,375,781.21
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(71,550,490.58)	(71,550,490.58)
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	17,986,956.29	5,486,838,334.34	5,504,825,290.63

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	440,931,300.00	724,642,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,837,600.00	2,960,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,837,600.00	2,960,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,837,600.00	2,960,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,837,600.00	2,960,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	437,093,700.00	721,682,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	399,578,700.00	381,332,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	399,578,700.00	381,332,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,515,000.00	340,349,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	17,200,000.00	335,415,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	20,000,000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	4,934,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	438,931,300.00	711,142,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	438,931,300.00	711,142,200.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,869,024.04	433,513,740.17
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	285,993,626.57	286,674,635.34
210101	Үндсэн цалин	210,469,000.00	205,079,335.34
210102	Нэмэгдэл	58,372,926.57	63,144,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,151,700.00	18,451,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,004,234.29	38,610,500.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,563,934.29	27,170,400.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,860,100.00	2,860,000.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,288,100.00	2,288,000.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	572,000.00	572,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,720,100.00	5,720,100.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	32,292,647.35	29,094,712.67
210301	Гэрэл цахилгааны зардал	19,142,462.00	14,784,885.95
210302	Түлш, халаалтын зардал	10,474,345.35	10,462,086.72
210303	Цэвэр, бохир усны зардал	2,675,840.00	3,847,740.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,564,681.83	9,232,662.16
210401	Бичиг хэрэг	1,638,517.00	1,760,230.00
210402	Тээвэр, шатахуун	2,385,500.00	1,724,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,316,065.83	4,628,302.16
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,224,599.00	1,120,130.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,486,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	-	486,000.00
210604	Урсгал засвар	-	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,858,000.00	3,778,000.00
210702	Дотоод албан томилолт	1,858,000.00	3,778,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,978,334.00	39,215,430.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	32,988,900.00	37,310,410.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	171,434.00	196,020.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	318,000.00	165,000.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		44,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,177,500.00	23,421,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,177,500.00	23,421,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,062,275.96	277,628,459.83
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,484,000.00	2,847,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,484,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	2,847,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,578,275.96	274,780,959.83
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,263,275.96	4,160,959.83
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	315,000.00	270,620,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,000,000.00	13,500,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,000,000.00	13,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,000,000.00	13,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,000,000.00	13,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,000,000.00	13,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(2,000,000.00)	(13,500,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	381,332,800.00	380,131,840.17	1,200,959.83	99.7
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	381,332,800.00	380,131,840.17	1,200,959.83	99.7
Бараа, үйлчилгээний зардал	381,332,800.00	380,131,840.17	1,200,959.83	99.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,304,600.00	286,674,635.34	629,964.66	99.8
Үндсэн цалин	205,708,600.00	205,079,335.34	629,964.66	99.7
Нэмэгдэл	63,144,300.00	63,144,300.00		100.0
Унаа, болон бусад нөхөн олговор	18,451,700.00	18,451,000.00	700.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,610,500.00	38,610,500.00		100.0
Тэтгэврийн даатгал	27,170,400.00	27,170,400.00		100.0
Тэтгэмжийн даатгал	2,860,000.00	2,860,000.00		100.0
ҮОМШӨ ний даатгал	2,288,000.00	2,288,000.00		100.0
Ажилгүйдлийн даатгал	572,000.00	572,000.00		100.0
Эрүүл мэндийн даатгал	5,720,100.00	5,720,100.00		100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,524,400.00	29,094,712.67	429,687.33	98.5
Гэрэл цахилгаан	15,151,500.00	14,784,885.95	366,614.05	97.6
Түлш, халаалт	10,494,700.00	10,462,086.72	32,613.28	99.7
Цэвэр, бохир ус	3,878,200.00	3,847,740.00	30,460.00	99.2
Хангамж, бараа материалын зардал	9,002,000.00	8,932,662.16	69,337.84	99.2
Бичиг хэрэг	1,760,600.00	1,760,230.00	370.00	100.0
Тээвэр (шатахуун)	1,724,000.00	1,724,000.00		100.0
Шуудан холбоо, интернэтийн төлбөр	4,594,900.00	4,528,302.16	66,597.84	98.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	922,500.00	920,130.00	2,370.00	99.7
Эд хогшил худалдан авах	486,000.00	486,000.00		100.0
Багаж, техник, хэрэгсэл	486,000.00	486,000.00		100.0
Томилолт, зочны зардал	1,599,600.00	1,578,000.00	21,600.00	98.6
Дотоод албан томилолт	1,599,600.00	1,578,000.00	21,600.00	98.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	7,259,600.00	7,233,530.00	26,070.00	99.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,346,000.00	5,328,510.00	17,490.00	99.7
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,500,000.00		100.0
Даатгалын үйлчилгээ	203,800.00	196,020.00	7,780.00	96.2
Тээврийн хэрэгслийн татвар	165,400.00	165,000.00	400.00	99.8
Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,400.00	44,000.00	400.00	99.1
Бараа үйлчилгээний бусад зардал	7,546,100.00	7,521,800.00	24,300.00	99.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,546,100.00	7,521,800.00	24,300.00	99.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
Бусад урсгал шилжүүлэг				
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж				
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	381,332,800.00	380,131,840.17	1,200,959.83	99.7

УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	381,332,800.00	377,171,840.17	4,160,959.83	
Улсын төсвөөс санхүүжих	381,332,800.00	377,171,840.17	4,160,959.83	
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		2,960,000.00	(2,960,000.00)	
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,960,000.00	(2,960,000.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	19	19		100.0
Үйлчлэх ажилтан	5	5		100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналтын журам боловсруулж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-наас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Нью эстимэйтор Аудит ХХК-ийн ахлах аудитор Ж.Үхэртар, аудитор Б.Халиунаа нар гүйцэтгэж, хяналтыг захирал Т.Бүжидмаа хэрэгжүүлсэн.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/009 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв нь олон улсын жишигт нийцсэн орчин үеийн технологи, багаж, тоног төхөөрөмж, мэргэшсэн боловсон хүчний нөөцөд тулгуурлан цэнгэг усны нөөцийг зөв зохистой ашиглах, хамгаалах, түүнтэй холбоотой байгаль орчныг хамгаалах, сорилт шинжилгээ хийж, усны чанар, төлөв байдлын талаар ашиглагч, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах, сургалт, сурталчилгаа, судалгааны ажил явуулах, мэргэжлийн болон хөндлөнгийн дүгнэлт гаргах, ус, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагыг усны талаарх мэдээллээр хангах, өсвөр залуу үе, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх үндсэн чиг үүрэгтэй Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчин, цэнгэг усны чиглэлээр сургалт сурталчилгаа, судалгаа шинжилгээний ажил явуулах

Тайлант хугацаанд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг шинэчлэгдсэн бөгөөд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзэв.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шилэн дансны хэрэгжилтэд дотоод аудит хийсэн бөгөөд 98.6 хувьтай гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 558,391.6 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 11,167.8 *мянган* төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувиар буюу 8,934.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71,550.5 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	270,620.0	270,620.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	64,577.9	63,539.3	(1,038.6)
Үндсэн хөрөнгө	5,511,797.9	5,170,666.0	(341,131.9)
Нийт хөрөнгө	5,576,375.8	5,504,825.3	(71,550.5)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,576,375.8	5,504,825.3	(71,550.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,576,375.8	5,504,825.3	(71,550.5)

Дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 270,620.0 мянган төгрөг болж 270,620.0 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны бодлогын зээл ТА9888МОН: Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай байгуулсан Ажил гүйцэтгэх №21/144 тоот гэрээний урьдчилгаа төлбөр тайлант оны 12 сард шилжиж орж ирсэнтэй холбоотойгоор ажил нь хийгдээгүй тул төсөвт буцаан төвлөрүүлж авлагаар бүртгэснээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд он удаан жил болсон найдваргүй авлага байхгүй байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,170,666.0 мян төгрөг болж 71,550.5 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 13,500.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 16,914.2 мян төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 541,800.2 мянган төгрөгөөр буюу 57.8 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжийн орлого байна. Энэ нь Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай байгуулсан Ажил гүйцэтгэх №21/144 тоот гэрээний урьдчилгаа төлбөр шилжиж орсноос шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 263,593.3 мянган төгрөгөөр буюу 47.9 хувиар өссөн буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан элэгдлийн зардал байна. Энэ нь өмнөх оны жилийн эцэст үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний залруулгаар барилга байгууламжийн дансны үлдэгдэл нэмэгдсэн мөн өмнөх оны жилийн эцэст элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглалтын хугацаа нь дууссан хэдий ч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгүүдийн ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн дансанд тусгаснаас шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 604,210.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд төсвийн төслөөс 215,473.9 мянган төгрөгөөр бууруулж 388,736.5 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант оны батлагдсан төсөв өмнөх оны төсвөөс 17,118.4 мянган төгрөгөөр буурсан нь Ковид 19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалжээ. 2021 оны 9 дүгээр сард тус төвийн төсөвт Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 7,403.7 мянган төгрөгөөр тодотгол хийж батлагдсан төсөв 381,332.8 мянган төгрөг болсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 381,332.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 2,960.0 мянган төгрөг, нийт 384,292.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 380,131.8 мянган төгрөгийг зарцуулж 4,161.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 380,131.8 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь цалин, ашиглалт, хангамж, бараа материал, томилолт, зочны зардал болон бусад зардлыг нийт 1,201.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71404	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	381,332.8	380,131.8	1,201.0	99.7
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	375,986.8	374,803.3	1,183.5	99.7
1.2	80219	Харуул хамгаалалт	5,346.0	5,328.5	17.5	99.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 29 арга хэмжээ тусгасан бөгөөд БОАЖЯ Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 11 арга хэмжээг 100%, 10 арга хэмжээг 90%, 7 арга хэмжээг 70%, 1 арга хэмжээг 50%-тай гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт 87.58% буюу 61.31 оноо, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт арга хэмжээний биелэлт 12.75 оноо, хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ 12.6 оноо нийт 86.66 оноогоор үнэлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.7 хувийн биелэлттэй, 0.3 хувь буюу 1,201.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд анхаарал татах асуудал байгаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу дараах байдлаар нийцлийн аудитын асуудлыг тайланд тусгасан болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв нь тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг оруулсан ба хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Мөн нийт 867,188.2 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 867,188.2 мянган төгрөгийг ил тод байршуулсан ба байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах тухай 1 албан шаардлага хүргүүлсэн. Аудитаар албан шаардлагыг 100 хувь хэрэгжүүлсэн гэж дүгнэлээ.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	-	-	100.0
Нийт дүн	1	-	1	-	-	-	-

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Азийн хөгжлийн банкны бодлогын зээл ТА9888МОН: Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөрийн 2-р үе шатны бүрэлдэхүүн хэсэг Иргэд, олон нийтийг мэдээлэл сурталчилгаагаар хангах хөтөлбөр (53028-001)-ийн хүрээнд олон нийттэй харилцах ажлуудыг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай байгуулсан Ажил гүйцэтгэх №21/144 тоот гэрээний ажлууд тайлант онд хийгдээгүй тул дараагийн аудитаар уг гэрээний хэрэгжилтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар дотоод хяналт шалгалтын журамтай холбоотой зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 1 алдаа, зөрчлийн дүн тогтоосон ерөнхий материаллаг байдлын дүнгээс хэтрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

4.1 Зөвлөмж

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Батлагдсан дотоод хяналт шалгалтын журмыг бүтэц орон тооны өөрчлөлттэй уялдуулж шинэчлээгүй бөгөөд тайлант онд уг журмын дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналт шалгалтын журмыг өөрийн үйл ажиллагаанд тохируулан шинэчилж мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс					
							Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар												
1	Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв	АХГ-2022/15/НА-СТА-ТХН	Батлагдсан дотоод хяналт шалгалтын журмыг бүтэц орон тооны өөрчлөлттэй уялдуулж шинэчлээгүй бөгөөд тайлант онд уг журмын дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.	Дотоод хяналт шалгалтын журмыг өөрийн үйл ажиллагаанд тохируулан шинэчилж, үйл ажиллагаанд мөрдөж ажиллах.	1						1	
ДҮН					1	-	0	-	0	-	1	-

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.